**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: СНАГ-2024/29/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот 2024 он | Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Б.Долгорсүрэн<br>Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn<br>Ахлах аудитор: О.Баярмаа<br>Утас: 261740 Цахим хаяг: bayarmaao@audit.gov.mn<br>“Тэд-Аудит” ХХК-ийн ерөнхий захирал: Ц.Сугармаа<br>Утас: 99151254 Цахим хаяг: ted.audit.llc@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/312

танай ______________-ны № ______________-т

АРЬСНЫ ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ Ц.УРАНЧИМЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Арьсны өвчин судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан эмнэлгийн угаалгын зориулалттай байрны 394 м.кв талбай бүхий газрыг ТӨБЗГ-ын 2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 4/02 дугаар тогтоолоор УБЕГ-т конторын зориулалттай шинэ байр барихад зориулж шилжүүлэхдээ тус төвийн эзэмшлийн газраас 6 м.кв газрыг илүү шилжүүлсэн.

**Аудитын гол асуудал**

Эрүүл мэндийн яамнаас 2021-2022 онд 7 нэр төрлийн нийт 80,381.9 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг хандиваар нийлүүлсэн бөгөөд тайлант жилд огт зарлага гараагүй 36,767.6 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл агуулахад хадгалагдаж байна.

**Бусад асуудлын хэсэг**

Эрүүл мэндийн сайдын 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А/161, 10 дугаар сарын 20-ны өдрийн А/372 дугаар тушаалаар тус төвийн ТУЗ-ийн дарга, гишүүдийг өөрчлөн батламжилсан боловч тайлант жилийн турш гишүүдийн ирц бүрдээгүй гэсэн

Z:\Yawsan_Bichig\2024\0223 SNAG-51.Docx

0001050596

шалтгаанаар хурал хийгээгүй, 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр хурал хийж, гүйцэтгэх захирлын гэрээний биелэлт, цалин урамшлын хэмжээ, 2023 оны төсвийг баталж, ТУЗ холбогдох хууль, журамд заасан эрх үүргээ хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2024\0223 SNAG-51.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| ДАНСНЫ КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **996,500,026.76** | **453,684,087.08** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **570,443,705.68** | **110,831,852.59** |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 570,443,705.68 | 110,831,852.59 |
| 31210 | Төгрөг | 570,443,705.68 | 110,831,852.59 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 565,961,335.68 | 109,084,352.59 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 4,482,370.00 | 1,747,500.00 |
| **33** | **АВЛАГА** | **23,722,115.00** | **270,200.00** |
| 33500 | Бусад авлага | 23,722,115.00 | 270,200.00 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 23,722,115.00 | 270,200.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 13,965,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 13,965,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **402,334,206.08** | **328,617,034.49** |
| 35100 | Түүхий эд материал | 361,981,243.59 | 263,707,908.80 |
| 35130 | Эм боох материал | 361,981,243.59 | 263,707,908.80 |
| 35400 | Хангамжийн материал | 40,352,962.49 | 64,909,125.69 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,786,550.00 | 11,960,469.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,324,232.60 | 35,457,439.80 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 906,264.89 | 2,528,130.89 |
| 35460 | Хүнсний материал | 21,747,075.00 | 8,374,246.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 6,588,840.00 | 6,588,840.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,095,609,153.44** | **4,349,344,100.71** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **4,095,609,153.44** | **4,349,344,100.71** |
| 39200 | Биет хөрөнгө | 3,893,343,770.00 | 4,150,072,883.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,212,087,798.60 | 3,331,881,975.80 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -550,954,904.79 | -644,069,098.82 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 126,515,000.00 | 98,563,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -121,830,368.72 | -56,635,000.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 2,390,303,574.25 | 2,152,574,190.65 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -1,418,653,558.35 | -1,014,722,647.08 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 569,149,479.00 | 432,358,588.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -313,273,249.99 | -149,878,125.20 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 202,265,383.44 | 199,271,217.36 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 232,493,682.00 | 216,964,144.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -30,228,298.56 | -17,692,926.64 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН I** | **5,092,109,180.20** | **4,803,028,187.79** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **2,584,000.00** | **5,249,670.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **2,584,000.00** | **5,249,670.00** |
| 41400 | Урьдчилж орсон орлого | 2,584,000.00 | 5,249,670.00 |
| 41440 | Бусад урьдчилж орсон орлого | 2,584,000.00 | 5,249,670.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,089,525,180.20** | **4,797,778,517.79** |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 5,089,525,180.20 | 4,797,778,517.79 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 2,470,206,581.32 | 2,470,206,581.32 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 2,470,206,581.32 | 2,470,206,581.32 |

| | | | |
|---|---|---|---|
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 228,811,516.16 | -62,935,146.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -111,070,041.68 | 228,811,516.16 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 339,881,557.84 | -291,746,662.41 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,390,507,082.72 | 2,390,507,082.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,092,109,180.20** | **4,803,028,187.79** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*/төгрөгөөр/*

| ДАНСНЫ КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,956,286,703.87** | **7,083,786,055.72** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,977,928,384.87** | **1,994,175,015.72** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,977,928,384.87 | 1,994,175,015.72 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,665,415,506.24 | 1,270,369,720.94 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,188,877,247.05 | 814,417,751.84 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 476,538,259.19 | 455,951,969.10 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 148,364,428.77 | 670,764,783.60 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 164,148,449.86 | 53,040,511.18 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **4,978,358,319.00** | **5,089,611,040.00** |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 4,978,358,319.00 | 5,089,611,040.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 4,978,358,319.00 | 5,089,611,040.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **6,616,405,146.03** | **7,375,532,718.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,616,405,146.03** | **7,375,532,718.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,455,341,113.03** | **7,310,366,018.13** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,244,185,540.87 | 3,738,397,526.70 |
| 210101 | Үндсэн цалин | 2,409,103,223.31 | 2,225,427,517.00 |
| 210102 | Нэмэгдэл | 412,923,590.65 | 975,327,416.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 70,585,000.00 | 144,000,000.00 |
| 210104 | Урамшуулал | 351,573,726.91 | 393,642,593.70 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 446,394,209.91 | 506,546,235.25 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 280,559,528.58 | 325,926,653.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 37,810,829.51 | 38,245,966.88 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 62,746,299.62 | 67,195,483.04 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,953,083.13 | 6,745,347.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 59,324,469.07 | 68,432,783.72 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 141,066,440.88 | 174,999,999.23 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 59,430,790.62 | 78,925,652.36 |
| 210302 | Түлш, халаалт | 26,113,953.26 | 31,145,106.01 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 55,521,697.00 | 64,929,240.86 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 142,882,398.91 | 166,537,367.50 |
| 210401 | Бичиг хэрэг | 32,096,292.00 | 27,589,384.20 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,402,443.00 | 10,770,453.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,513,688.62 | 9,559,969.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 73,848,000.60 | 76,648,161.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,021,974.69 | 41,969,400.10 |
| 2105 | Нормативт зардал | 1,852,609,378.42 | 1,636,672,238.50 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,600,508,348.42 | 1,333,369,023.50 |
| 210502 | Хоол, хүнс | 231,240,230.00 | 291,682,415.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 20,860,800.00 | 11,620,800.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 121,954,606.00 | 391,336,905.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,722,000.00 | 6,017,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 405,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 116,232,606.00 | 384,914,605.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 23,752,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 23,752,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 70,037,846.00 | 90,733,119.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 55,093,176.00 | 71,838,224.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 6,000,000.00 | 8,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 285,120.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 254,576.00 | 254,576.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,375,500.00 | 8,305,300.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,314,594.00 | 2,049,899.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 436,210,692.04 | 581,390,626.95 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,469,953.42 | 62,044,490.62 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,080,432.00 | 2,775,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 391,660,306.62 | 407,287,321.74 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **161,064,033.00** | **65,166,700.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 161,064,033.00 | 65,166,700.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 78,254,033.00 | 36,645,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 82,810,000.00 | 28,521,500.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **339,881,557.84** | **-182,462,847.82** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **109,283,814.59** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | - | 109,283,814.59 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **339,881,557.84** | **-291,746,662.41** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*/төгрөгөөр/*

| ДАНСНЫ КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **6,768,203,707.24** | **6,386,098,345.94** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,584,807,769.24** | **1,291,237,635.94** |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,584,807,769.24 | 1,291,237,635.94 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,584,807,769.24 | 1,291,237,635.94 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,165,955,132.05 | 837,869,666.84 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 418,852,637.19 | 453,367,969.10 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,183,395,938.00** | **5,094,860,710.00** |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 5,183,395,938.00 | 5,094,860,710.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,183,395,938.00 | 5,094,860,710.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **6,065,397,860.15** | **6,746,168,899.03** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **6,065,397,860.15** | **6,746,168,899.03** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,904,333,827.15** | **6,681,002,199.03** |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 3,258,235,108.15 | 3,740,587,984.22 |
| 210101 | Үндсэн цалин | 2,300,310,701.43 | 2,058,960,796.22 |
| 210102 | Нэмэгдэл | 626,675,160.23 | 1,050,107,838.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 104,007,829.00 | 144,669,660.00 |
| 210104 | Урамшуулал | 227,241,417.49 | 486,849,690.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 432,344,642.64 | 504,355,777.73 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 272,922,001.10 | 331,431,536.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 47,715,964.19 | 38,848,442.47 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 49,726,966.35 | 66,435,228.65 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,630,882.82 | 7,047,347.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 56,348,828.18 | 60,593,222.47 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 141,066,440.88 | 174,999,999.23 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 59,430,790.62 | 78,925,652.36 |
| 210302 | Түлш, халаалт | 26,113,953.26 | 31,145,106.01 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 55,521,697.00 | 64,929,240.86 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 132,217,393.00 | 147,197,288.70 |
| 210401 | Бичиг хэрэг | 21,503,303.00 | 22,280,382.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 7,500,000.00 | 12,069,200.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 11,513,688.62 | 9,559,969.20 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 63,964,370.40 | 67,713,039.50 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 27,736,030.98 | 35,574,698.00 |
| 2105 | Нормативт зардал | 1,751,804,754.06 | 1,498,053,433.53 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,495,065,769.06 | 1,207,450,897.53 |
| 210502 | Хоол, хүнс | 246,711,485.00 | 278,249,586.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,027,500.00 | 12,352,950.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 58,265,500.00 | 413,823,805.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,139,400.00 | 24,999,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 985,000.00 | 1,155,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 53,141,100.00 | 387,668,305.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 17,040,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 17,040,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 84,246,746.00 | 109,118,919.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 60,540,876.00 | 83,102,224.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 6,000,000.00 | 8,000,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 285,120.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 254,576.00 | 254,576.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 8,312,700.00 | 9,333,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,314,594.00 | 2,049,899.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 7,824,000.00 | 6,094,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 46,153,242.42 | 75,824,991.62 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 32,944,550.42 | 61,999,991.62 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,208,692.00 | 13,825,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **161,064,033.00** | **65,166,700.00** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 161,064,033.00 | 65,166,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 78,254,033.00 | 53,626,700.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 82,810,000.00 | 11,540,000.00 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **702,805,847.09** | **-360,070,553.09** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **168,585,280.00** | **99,541,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **168,585,280.00** | **99,541,300.00** |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 168,585,280.00 | 99,541,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 168,585,280.00 | 99,541,300.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-168,585,280.00** | **-99,541,300.00** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **534,220,567.09** | **-459,611,853.09** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 36,223,138.59 | 570,443,705.68 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 570,443,705.68 | 110,831,852.59 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*/төгрөгөөр/*

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ | ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ | ХУРИМТЛАГДСАН ДҮН | ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦООНЫ НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,470,206,581.32** | **2,390,507,082.72** | **-111,070,041.68** | **4,749,643,622.36** |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,470,206,581.32 | 2,390,507,082.72 | -111,070,041.68 | 4,749,643,622.36 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | - | - | 339,881,557.84 | 339,881,557.84 |
| **4** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,470,206,581.32** | **2,390,507,082.72** | **228,811,516.16** | **5,089,525,180.20** |
| 5 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,470,206,581.32 | 2,390,507,082.72 | 228,811,516.16 | 5,089,525,180.20 |
| 6 | Тайлант үеийн үр дүн | | | -291,746,662.41 | -291,746,662.41 |
| **7** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,470,206,581.32** | **2,390,507,082.72** | **-62,935,146.25** | **4,797,778,517.79** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*/төгрөгөөр/*

| ДАНСНЫ КОД | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | ЗӨРҮҮ | ХУВЬ |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **7,102,709,900.00** | **6,845,710,199.03** | **256,999,700.97** | **96.4** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **7,102,709,900.00** | **6,845,710,199.03** | **256,999,700.97** | **96.4** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **6,863,709,900.00** | **6,780,543,499.03** | **83,166,400.97** | **98.8** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **3,618,577,300.00** | **3,740,587,984.22** | **-122,010,684.22** | **103.4** |
| 210101 | Үндсэн цалин | 1,964,544,500.00 | 2,060,272,303.22 | -95,727,803.22 | 104.9 |
| 210102 | Нэмэгдэл | 1,006,195,500.00 | 1,050,107,838.00 | -43,912,338.00 | 104.4 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 146,753,400.00 | 144,669,660.00 | 2,083,740.00 | 98.6 |
| 210104 | Урамшуулал | 457,883,900.00 | 485,538,183.00 | -27,654,283.00 | 106.0 |
| 210105 | Гэрээт ажлын цалин | 43,200,000.00 | | 43,200,000.00 | 0.0 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **473,635,100.00** | **504,355,777.73** | **-30,720,677.73** | **106.5** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 305,531,000.00 | 331,431,536.69 | -25,900,536.69 | 108.5 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 36,584,600.00 | 38,848,442.47 | -2,263,842.47 | 106.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 61,659,300.00 | 66,435,228.65 | -4,775,928.65 | 107.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 7,142,500.00 | 7,047,347.45 | 95,152.55 | 98.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 62,717,700.00 | 60,593,222.47 | 2,124,477.53 | 96.6 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **175,000,000.00** | **174,999,999.23** | **0.77** | **100.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 75,800,000.00 | 78,925,652.36 | -3,125,652.36 | 104.1 |
| 210302 | Түлш, халаалт | 30,600,000.00 | 31,145,106.01 | -545,106.01 | 101.8 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 68,600,000.00 | 64,929,240.86 | 3,670,759.14 | 94.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **149,244,000.00** | **147,197,288.70** | **2,046,711.30** | **98.6** |
| 210401 | Бичиг хэрэг | 26,728,000.00 | 22,280,382.00 | 4,447,618.00 | 83.4 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,183,000.00 | 12,069,200.00 | -886,200.00 | 107.9 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 12,000,000.00 | 9,559,969.20 | 2,440,030.80 | 79.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 66,000,000.00 | 67,713,039.50 | -1,713,039.50 | 102.6 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 33,333,000.00 | 35,574,698.00 | -2,241,698.00 | 106.7 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,660,403,500.00** | **1,498,053,433.53** | **162,350,066.47** | **90.2** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,371,000,000.00 | 1,208,700,897.53 | 162,299,102.47 | 88.2 |
| 210502 | Хоол, хүнс | 277,000,000.00 | 276,999,586.00 | 414.00 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 12,403,500.00 | 12,352,950.00 | 50,550.00 | 99.6 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **572,400,000.00** | **512,089,105.00** | **60,310,895.00** | **89.5** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 120,000,000.00 | 114,569,000.00 | 5,431,000.00 | 95.5 |
| 210602 | Тавилга | 16,000,000.00 | 8,696,000.00 | 7,304,000.00 | 54.4 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 12,150,800.00 | 1,155,800.00 | 10,995,000.00 | 9.5 |
| 210604 | Урсгал засвар | 424,249,200.00 | 387,668,305.00 | 36,580,895.00 | 91.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **19,500,000.00** | **17,040,000.00** | **2,460,000.00** | **87.4** |
| 210702 | Дотоод албан томилолт | 19,500,000.00 | 17,040,000.00 | 2,460,000.00 | 87.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **116,550,000.00** | **110,394,919.00** | **6,155,081.00** | **94.7** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 82,000,000.00 | 84,378,224.00 | -2,378,224.00 | 102.9 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 8,000,000.00 | 8,000,000.00 | - | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 350,000.00 | 285,120.00 | 64,880.00 | 81.5 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 300,000.00 | 254,576.00 | 45,424.00 | 84.9 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 400,000.00 | - | 400,000.00 | 0.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 14,400,000.00 | 9,333,100.00 | 5,066,900.00 | 64.8 |
| 210807 | Газрын төлбөр | 2,100,000.00 | 2,049,899.00 | 50,101.00 | 97.6 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 9,000,000.00 | 6,094,000.00 | 2,906,000.00 | 67.7 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **78,400,000.00** | **75,824,991.62** | **2,575,008.38** | **96.7** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 56,600,000.00 | 61,999,991.62 | -5,399,991.62 | 109.5 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 21,800,000.00 | 13,825,000.00 | 7,975,000.00 | 63.4 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **239,000,000.00** | **65,166,700.00** | **173,833,300.00** | **27.3** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **239,000,000.00** | **65,166,700.00** | **173,833,300.00** | **27.3** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 200,000,000.00 | 53,626,700.00 | 146,373,300.00 | 26.8 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 39,000,000.00 | 11,540,000.00 | 27,460,000.00 | 29.6 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **7,102,709,900.00** | **6,384,350,845.94** | **718,359,054.06** | **89.9** |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **5,071,699,600.00** | **5,104,860,710.00** | **-33,161,110.00** | **100.7** |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 5,071,699,600.00 | 5,104,860,710.00 | -33,161,110.00 | 100.7 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **2,031,010,300.00** | **1,279,490,135.94** | **751,520,164.06** | **63.0** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 862,000,000.00 | 826,122,166.84 | 35,877,833.16 | 95.8 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 603,049,000.00 | 453,367,969.10 | 149,681,030.90 | 75.2 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 565,961,300.00 | 0 | 565,961,300.00 | 0.0 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **0** | **570,443,705.68** | **-570,443,705.68** | **0.0** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **0** | **110,831,852.59** | **-110,831,852.59** | **0.0** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **135** | **129** | **6** | **95.5** |
| 620001 | Удирдах ажилтан | 16 | 16 | **0** | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 79 | 76 | **3** | 96.2 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 40 | 37 | **3** | 92.5 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 5,129.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэнтэй холбоотойгоор 2 зөвлөмж, 2 албан шаардлагыг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 5,129.1 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 61,034.9 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

**Албан шаардлага**

**1.Бараа материалтай холбоотой асуудал**

Тус төвийн захирал аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан "Бараа материал худалдан авах тухай гэрээ"-нд худалдан авах барааны тоо ширхэг, үнэ, нийлүүлэх хугацааг нарийвчлан тусгаагүй, гэрээний хэрэгжих хугацааг 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдөр хүртэл буюу төсвийн жил дамнуулан хийсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.”, 7.3-д “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна”, 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэж заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Ханган нийлүүлэх байгууллагатай хийсэн гэрээнүүдийг хавсралтаар баталгаажуулж, гэрээнд худалдан авах барааны тоо ширхэг, үнэ, нийлүүлэх хугацааг нарийвчлан тусгаж, гэрээний хэрэгжих хугацааг төсвийн жил дамнуулан хийхгүй байх, гэрээний гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах талаар албан шаардлага хүргүүлэв.

**2.Эм, эмнэлгийн хэрэгслийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

Эм, эмнэлгийн хэрэгсэл, худалдан авах ажиллагааг судалгаа тооцоонд үндэслэн оновчтой төлөвлөөгүйгээс тендерт шалгарсан зарим ханган нийлүүлэгч байгууллагуудтай хийсэн эм, эмнэлгийн хэрэгслийн гэрээний гүйцэтгэл 20.0-45.5 хувийн биелэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1."төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Тасаг, албадын эм, эмнэлгийн хэрэгслийн жилийн хэрэгцээ шаардлагыг бодит нөхцөл байдалд уялдуулан тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж байх талаар албан шаардлага хүргүүлэв.

**Зөвлөмж**

**1.Орлоготой холбоотой асуудал**

<u>*Илрүүлэлт*</u>: Төлбөртэй тусламж үйлчилгээний нэмэлт орлогын төлөвлөгөөг нэр төрөл, сар, улирлаар төлөвлөж, захирлын тушаалаар батлуулаагүй, нийт дүнгээр төлөвлөж, тушаасан дүнгээр орлогыг бүртгэсэн байна. Тухайлбал, Төлбөртэй орны тоо болон орлогыг өвчтөнд үзүүлж буй тусламж үйлчилгээний ор хоног, орны эргэлтийн хугацааг хуанлийн календарийн өдөртэй уялдуулаагүй, сар улирлын тайланг тасаг бүрээр тооцож, хяналт тавьж ажиллаагүй байна.

Энэ нь Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 49, А/118 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээ болон нэмэлт үйлчилгээ үзүүлж олсон орлогыг зарцуулах үлгэрчилсэн журам"-д заасантай нийцэхгүй байна.

<u>*Өгсөн зөвлөмж*</u>: Төлбөртэй тусламж үйлчилгээний орлогыг төлөвлөх, зарцуулах, хяналт тавих журмыг боловсруулан мөрдөж, орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах.

**2.Дотоод хяналттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/08 дугаар тушаалаар Ш.Гантуяаг санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийх, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх гэрээт ажилтнаар томилсон бөгөөд тайлант онд дотоод хяналт шалгалтын чиглэлээр 8 ажил төлөвлөж, баталсан байна. Гэтэл хийсэн ажил тодорхой бус, шалгасан асуудлын талаар тайлан бичиж, дүгнэлт, зөвлөмж гаргаагүй, ерөнхий ажлын жагсаалт үйлдсэн, нягтлан бодогч нарын ажилд зөвлөн тусалдаг гэх боловч "дотоод хяналт, зөвлөн туслах ажлын тайлан"-д дотоод хяналт, дотоод аудитын үйл ажиллагааны талаар тодорхой тусгаагүй байгаа тул дотоод хяналт үр нөлөөгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Дотоод аудиторыг сонгох сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод зохион байгуулж, орон тоогоор үр дүнтэй ажиллуулах

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материал худалдан авах гэрээний хэрэгжилт хангалтгүй | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Эм, эмнэлгийн хэрэгслийн гэрээний хэрэгжилт бүрэн бус | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| Нэмэлт тусламж үйлчилгээний орлогыг бодитой төлөвлөөгүй | 1 | - | | | | | 1 | 5,129.1 | | | | |
| Дотоод хяналтын зөвлөх үйлчилгээ үр дүнгүй | 1 | - | | | | | 1 | - | | | | |
| Дүн | 4 | - | | | 2 | - | 2 | 5,129.1 | | | | |

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 № 64/А0150092 Улаанбаатар хот
СНАГ-2024/29/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материал худалдан авах гэрээнд худалдан авах тоо ширхэг, гэрээний үнэ, бараа нийлүүлэх хуваарь, хугацааг тусгаагүй, гэрээний хугацааг 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс 2024 оны 02 дугаар сарын 23-ны өдрийг хүртэл хугацаанд хэрэгжихээр төсвийн жил дамнуулан гэрээг байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Төсвийн жил нь тухайн оны 1 дүгээр сарын 01-ний өдөр эхэлж, тухайн оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно”, 7.3-д “Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна”, 43 дугаар зүйлийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа материал худалдан авах тухай гэрээнд худалдан авах тоо ширхэг, гэрээний үнэ, бараа нийлүүлэх хуваарь, хугацааг тодорхой тусгаагүй, гэрээний хэрэгжих хугацааг төсвийн жилд багтааж хийх арга хэмжээ аваагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2023 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал /Ц.Уранчимэг/, Санхүүгийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Б.Мядаг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ДОЛГОРСҮРЭН

“ТЭД-АУДИТ” ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Ц.СУГАРМАА

АТА9693 9006109
2023930583

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2024\0223 SNAG-24.Docx

0001080216

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 дугаар сарын 23 № 65/А0150092 Улаанбаатар хот

СНАГ-2024/29/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Арьсны өвчин судлалын үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг тооцоо, судалгаанд үндэслэн оновчтой төлөвлөөгүйгээс тендерт шалгарсан зарим ханган нийлүүлэгч байгууллагуудтай хийсэн эм, эмнэлгийн хэрэгслийн гэрээний гүйцэтгэл 20.0-45.5 хувийн биелэлттэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах ажиллагааг тооцоо, судалгаанд үндэслэн бодитой төлөвлөөгүй, гэрээний гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг Үндэсний аудитын газарт 2023 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн дотор ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Арьсны өвчин судлалын үндэсний төвийн захирал /Ц.Уранчимэг/, Санхүүгийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Б.Мядаг/ нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮ-НИЙЦЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ДОЛГОРСҮРЭН

"ТЭД-АУДИТ" ХХК-ИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ Ц.СУГАРМАА

АТА9693 9006109
9023030583

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2024\0223 SNAG-24.Docx*

0001080218